



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 531

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор  
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д дор дурдсан дараах 4 дүгээр зүйлийн 4.4<sup>1</sup>, 8 дугаар зүйлийн 8.2, 10 дугаар зүйлийн 10.1.13, 10.1.14, 10.1.15, 10.2<sup>1</sup>, 10.2<sup>2</sup>, 10.2<sup>3</sup> дахь заалтыг тус тус нэмсүгэй.

1/ 4 дүгээр зүйлийн 4.4<sup>1</sup> дахь хэсэг:

“4.4<sup>1</sup> Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй байна.”;

2/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

“8.2 ББСБ нь хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны үзүүлэлтийг тооцохдоо гаргасан хаалттай өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулах замаар тооцох бөгөөд энэхүү харьцаа нь 50 хувиас ихгүй байна. Хаалттай өрийн бичгийн тайланг энэхүү журмын арвангуравдугаар хавсралтын дагуу гаргана.”;

3/ 10 дугаар зүйлийн 10.2<sup>1</sup>, 10.2<sup>2</sup>, 10.2<sup>3</sup> дахь хэсгүүд:

“10.2<sup>1</sup> Активын өгөөжийг тооцохдоо татварын өмнөх цэвэр ашгийг нийт активын дундажтай харьцуулан тооцно.”;

10.2<sup>2</sup> Өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцохдоо татварын өмнөх цэвэр ашгийг өөрийн хөрөнгийн дундажтай харьцуулан тооцно.;

10.2<sup>3</sup> Долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээг энэхүү журмын 14 дүгээр хавсралтын дагуу гаргаж дараа долоо хоногийн эхний хагаст Монголбанкинд, сар тутмын валют арилжааны тухай мэдээг энэхүү журмын 15 дугаар хавсралтын дагуу гаргаж, дараа сарын 10-ны дотор Хороонд ирүүлнэ.”.

000903

**4/ 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10.1.13, 10.1.14, 10.1.15 дахь заалтууд:**

“10.1.13 хаалттай өрийн бичиг, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тайлан (Хавсралт 13); ”;

“10.1.14 долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээ /Хавсралт 14/; ”;

“10.1.15 сар тутмын валют арилжааны тухай мэдээ /Хавсралт 15/. ”;

2. Мөн журмын “НАЙМ” дугаар зүйлийн “...ҮЗҮҮЛЭЛТ” гэсний ард “ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧГИЙН ҮЗҮҮЛЭЛТ” гэж нэмсүгэй.

3. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1.2.3, 1.2.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

**1/ 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1.2.3, 1.2.5 дахь заалтууд:**

“1.2.3 “Хоёрдогч өглөг” гэдэгт хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийн бичгийг; ”;

“1.2.5 “Гадаад валютын ханийн эрсдэл” гэдэгт төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэлийг”.

4. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...ердийн...” гэснийг “...энгийн...” гэж, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтын “...хувь нийлүүлэгч...” гэснийг “...хувьцаа эзэмшигч...” гэж, 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 11.4.3 дахь заалтын “дүрмийн сан...” гэснийг “хувь нийлүүлсэн хөрөнгө...” гэж, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12.1.4 дэх заалтын “...хувь нийлүүлэгч...” гэснийг “...хувьцаа эзэмшигч...” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “...болон 5-аас дээш жилийн хугацаатай...” гэснийг хассугай.

6. Журамд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

